

I-IV/2021


Тархаасан: 2021 оны 05 дугаар сарын 15



## Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 48.2 хувиар өслөө

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2021 оны эхний 4 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 6.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.0 (48.2%) их наяд төгрөгөөр өслөө. Үүнд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 1.6 (59.2%) их наяд төгрөгөөр, боловсруулах аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 370.1 (38.3%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна. Мөн цахилгаан хий, уур, агааржуулалтын салбарын үйлдвэрлэл 45.9 (9.6%) тэрбум төгрөгөөр, ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал, зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагааны салбарын үйлдвэрлэл 6.3 (14.3%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Зураг 1. Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл, салбараар, сараар, тэрбум төгрөг



Нийт үйлдвэрлэл 2021 оны 4 дүгээр сард 1.5 их наяд төгрөг болж, өмнөх сараас 157.8 (9.4%) тэрбум төгрөгөөр буурчээ. Үүнд уул уурхай, олборлох салбарын нийт үйлдвэрлэл 96.3 (8.3%) тэрбум төгрөг, боловсруулах аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 50.8 (13.5%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2021 оны 4 дүгээр сард урьдчилсан гүйцэтгэлээр 1.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 446.6 (72.9%) тэрбум төгрөгөөр өсөхөд нүүрс олборлолт 171.3 (3.5 дахин) тэрбум төгрөгөөр, газрын тос олборлолт 74.2 (15.9 дахин) тэрбум төгрөгөөр, металлын хүдэр олборлолт 228.9 (46.7%) тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт 2021 оны эхний 4 сарын урьдчилсан гүйцэтгэлээр алт, зэсийн баяжмал, металл агуулгаараа, төмрийн хүдэр, хүрэн нүүрс, хайлуур жонш, чулуун нүүрс болон газрын тосны олборлолт өмнөх оны мөн үеэс 6.4 хувиас 3.6 дахин, боловсруулах аж үйлдвэрийн салбарт катодын зэс, 99%, согтууруулах ундаа, гурил, шингэн сүү, самнасан ноолуур, цемент, нүүрсэн шахмал түлш, малын мах, баяжуулсан нүүр, янжуур тамхи зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 1.4 хувиас 9.8 дахин өссөн байна.

Хүснэгт 1. Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл

Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2020		2021*		2021* I-IV	
		IV	I-IV	IV	I-IV	2020	I-IV
<b>Уул уурхай, олборлох аж үйлдвэр</b>							
Чулуун нүүрс	мян.т	572.9	6 713.2	2 301.9	12 498.2	186.2	
Хүрэн нүүрс	мян.т	419.6	2376.7	537.4	2 729.8	114.9	
Газрын тос	мян.баррел	97.7	559.3	496.4	2 005.6	3.6 <sup>1</sup>	
Зэсийн баяжмал, металл агуулгаараа	мян.т	103.6	411.6	111.6	453.4	110.1	
Алт	кг	1 324.0	3 735.6	1 308.6	3 975.7	106.4	
Төмрийн хүдэр	мян.т	1 100.1	1 995.8	873.2	2 291.4	114.8	
Хайлуур жонш	мян.т	6.5	33.2	7.3	40.7	122.7	
<b>Боловсруулах аж үйлдвэр</b>							
Малын мах	т	1 094.9	3 463.9	1 747.9	7 427.8	2.1 <sup>1</sup>	
Шингэн сүү	мян.л	4 224.8	14 706.2	4 986.6	18 017.3	122.5	
Гурил	т	19 473.2	75 825.9	23 780.5	82 633.5	109.0	
Цэвэр спирт	мян.л	1 861.4	4 612.9	637.3	3 846.9	83.4	
Согтууруулах ундаа	мян.л	1 402.1	7 966.8	1 400.1	8 681.5	109.0	
Ус, ундаа, жүүс	мян.л	19 538.1	112 862.5	34 437.2	103 480.6	91.7	
Янжуур тамхи	мян.блок	110.7	110.7	287.3	1 086.9	9.8 <sup>1</sup>	
Амны хаалт	мян.ш	3 118.5	5 195.1	147.5	4 718.3	90.8	
Эмчилгээ, урьдчилан сэргийлэх зориулалттай бусад төрлийн эм, ариутгалын бэлдмэл	мян.л	15.1	173.0	21.1	104.3	60.3	
Ноолууран сүлжмэл эдлэл	мян.ш	121.7	405.2	11.5	159.7	39.4	
Самнасан ноолуур	т	23.4	98.0	7.6	143.7	146.6	
Баяжуулсан нүүрс	т	46.3	575.9	378.1	1 784.7	3.1 <sup>1</sup>	
Нүүрсэн шахмал түлш	мян.т	15.0	188.2	53.3	389.2	2.1 <sup>1</sup>	
Цемент	мян.т	111.0	145.3	91.6	232.9	160.3	
Шохой	т	2 365.4	21 115.6	5 276.5	20 907.8	99.0	
Катодын зэс, 99%	т	741.8	3 189.9	808.4	3 233.3	101.4	
Металл бэлдэц	т	3 224.4	7 882.9	1 797.3	5 398.7	68.5	

<sup>1</sup>дахин их

Харин боловсруулах аж үйлдвэрийн салбарт шохой, ус, ундаа, жүүс, амны хаалт, амны хаалт, спирт, металл бэлдэц, гар ариутгагч, , ноолууран сүлжмэл эдлэл зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 1.0-60.6 хувиар буурсан байна.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2021 оны эхний 4 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 7.9 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 3.5 (81.8%) их наяд төгрөгөөр өслөө. Үүнд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулалт 3.1 (2.2 дахин) их наяд төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.


## Хүснэгт 2. Аж үйлдвэрийн борлуулсан бүтээгдэхүүн, салбараар

Салбар	2020		2021*			2021* I-IV
	IV	I-IV	IV	I-IV	гадаадад	2020 I-IV
	тэрбум төгрөг					хувь
<b>Нийт дүн</b>	<b>1 141.2</b>	<b>4 324.6</b>	<b>1 659.8</b>	<b>7 863.9</b>	<b>5 287.2</b>	<b>181.8</b>
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	690.5	2 511.4	1 144.5	5 578.3	4 811.9	2.2 <sup>1</sup>
Боловсруулах аж үйлдвэр	332.6	1 286.4	383.3	1 707.4	475.3	132.7
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж	106.8	482.7	117.9	525.9	-	109.0
Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал, зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	11.4	44.1	14.0	52.3	-	118.6

<sup>1</sup>дахин их

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн өмнөх оны мөн үеэс 3.1 (2.2 дахин) их наяд төгрөгөөр өсөхөд металлын хүдэр олборлолтын салбарын борлуулалт 1.8 (2.0 дахин) их наяд төгрөгөөр, нүүрс олборлолтын салбарын борлуулалт 1.1 (2.9 дахин) их наяд төгрөгөөр, газрын тос олборлолтын салбарын борлуулалт 228.8 (5.0 дахин) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлөв.

Зураг 2. Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн борлуулсан бүтээгдэхүүн, салбараар, сараар, тэрбум төгрөг



Нийт борлуулсан бүтээгдэхүүний 5.3 их наяд төгрөг буюу 67.2 хувийг гадаад зах зээлд борлуулжээ. Гадаад зах зээлд борлуулсан нийт бүтээгдэхүүний 4.8 их наяд төгрөг буюу 91.0 хувийг уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн эзэлж байна. Гадаад зах зээлд борлуулсан уул уурхайн бүтээгдэхүүний 62.3 хувийг металлын хүдэр олборлолтын салбарын бүтээгдэхүүн, 30.2 хувийг нүүрс олборлолтын салбарын бүтээгдэхүүн, 5.9 хувийг газрын тос олборлолтын салбарын бүтээгдэхүүн, 1.5 хувийг бусад ашигт малтмал олборлолтын салбарын бүтээгдэхүүн эзэлж байна.

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн индекс (улирлын нөлөөллийг арилгасан тооцоо) 2021 оны 4 дүгээр сард 170.8 (2015=100) болж, өмнөх оны мөн үеэс 79.4 хувиар, өмнөх оны эцсээс 24.3 хувиар өссөн байна.

### Ойлголт, тодорхойлолт:

Эдийн засгийн үйл ажиллагааны ангилал: НҮБ-аас гишүүн орнууддаа мөрдөхийг зөвлөмж болгосон эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны олон улсын стандарт ангилалд нийцүүлэн боловсруулсан үндэсний ангилал юм.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл: Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн: Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн (биет хэмжээний) индекс: Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг сар бүрийн мэдээлэлд хамруулан судалж, Ласпейрсийн биет хэмжээний индексийн томъёог ашиглан тооцно.

### Тооцох аргачлал:

Ласпейрсийн биет хэмжээний индексийн томъёо:

$$I_{LQ} = \frac{\sum(Q_t \cdot P_0)}{\sum(Q_0 \cdot P_0)} \cdot 100 = \sum\left(\frac{Q_t}{Q_0}\right) \cdot W_0 \cdot 100$$

Q<sub>t</sub>- Бүтээгдэхүүний тайлант үеийн биет хэмжээ

Q<sub>0</sub>- Бүтээгдэхүүний суурь үеийн биет хэмжээ

P<sub>0</sub>- Бүтээгдэхүүний суурь үеийн үнэ

W<sub>0</sub>- Жин

**Тайлбар:** ААНБ-ын мэдээнд суурилсан гүйцэтгэл

**Эх үүсвэр:** ҮСХ, Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл, борлуулалтын сарын мэдээ



**Ангилал, код:** Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал

### Мэдээлэл авах линкүүд:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

**Дараагийн мэдээ тархаах хуваарь:** 2021 оны 6 дугаар сарын 15

Эдийн засгийн статистикийн  
газрын дарга Э.Эрдэнэсан  
Утас : (976-51)-266414

Эдийн засгийн статистикийн газрын  
статистикч Б.Уянгаа  
статистикч Б.Энхболд  
Утас : (976-51)-261563